

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/17/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enhtsetsege@audit.gov.mn

Аудитор:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	4
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11-19
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19

Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.19 № 1-6/88

танай _____ -ны № _____ -т

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Б.ОЮУНБЯМБА
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020039

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Даланжаргалан сумын ЗДТГ-ын дарга Б.Оюунбямба Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 15-аас 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аймгийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/47 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Даланжаргалан сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүндрэлгүйгээр иргэдэд хүргэхэд оршино.

Даланжаргалан сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Даланжаргалан сумын ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. /нийцээгүй байна/

Даланжаргалан сумын ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд асолюс программ хангамж ашигладаг байна.

Даланжаргалан сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Даланжаргалан сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн

тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,570,657.4 мянган төгрөгөөс тооцон 15,706.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 17,090.4 мянган төгрөгөөр тооцсон нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 226,147.30 мянган төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	154.9	3430.0	3275.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	60,206.40	62,593.30	2386.9
Үндсэн хөрөнгө	1,415,623.50	1,636,108.80	220485.3
Нийт хөрөнгө	1,475,984.80	1,702,132.10	226,147.30
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,475,984.80	1,702,132.10	226,147.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,475,984.80	1,702,132.10	226,147.30

Авлага дансны үлдэгдэл өссөн нь нэмэлт дансны үлдэгдэл 3430.0 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагаар бүртгэсэнтэй холбоотой. Бараа материалын дансны үлдэгдэл 2386.9 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст сэлбэг хэрэгслийн дансанд 2270.0 мянган төгрөгийн дугуй, аж ахуйн материалд оготно хулгана устгалын төхөөрөмж 2100.0 мянган төгрөгөөр, байгаль хамгаалагчийн хувцас 400.0 мянган төгрөг, ажилчдын хувцас 2400.0 мянган төгрөг, Цахилгаан монтаж 800.0 мянган төгрөг, Шинээр баригдсан худгийн насос 360,0, Смарт худгийн гэр интернэт 300.0 мянган төгрөг, Гадна гэрэлтүүлэг 240.0 мянган төгрөгийн материалууд шинээр нэмэгдсэн, харин барилгын засварын материалын данс 7190.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. 2019 онд 48239.4 мянган төгрөгийн бараа материал төсвийн хөрөнгөөр, шинэ баг ашиглалтад ороход 74.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 548.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 6540.0 мянган төгрөгийн нүүрс хандиваар орсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 98,700.0 мянган төгрөгийн 2ш хогийн машин 1ш фургон автомашин, 1ш мотоцикл хандив тусламжаар, 45,802.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн 16031.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр 29,771.1 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 21,776.6 төгрөгийн тавилга эд хогшлын 3,822.0

төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр 17,954.6 төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар тус тус авсан байна. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 56,959.4 мянган төгрөгийн 32,259.4 төгрөгөөр гэрэлт баганын засвар хийсэн. Мөн 17,700.0 төгрөгөөр Далантүрүүд авто зогсоол барьж зам гүүрийн байгууламж дансанд орлогод тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,702,132.01 мянган төгрөг болж 226,147.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь ОНХсангаар хийгдсэн ажил болон бусад үнэ төлбөргүй орлогоос шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Даланжаргалан сумын ЗДТГазар нь тайлант онд 350,517.9 мянган төгрөгийн санхүүжилт орохоос гүйцэтгэлээр 350,367.7 мянган төгрөгийн орсон байна.

Хүснэгт 2. Санхүүжүүлэх эх үүсвэр

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төсвөөс урсгал санхүүжилт	349,517.9	349,517.9		100.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,000.0	849.8	150.2	85.0
Нийт дүн	350,517.9	350,367.7	150.2	99.9

Үндсэн үйл ажиллагааны орлог 150.2 мянган төгрөгөөр тасарсан нь төрийн албан хаагчийн 2 байр хүнгүй байснаас түрээсийн орлого дутуу орсноос шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 350,517.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 350,517.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 349,517.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 349,130.9 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна. АО-оос төлөх НДШ 107.5 мянган төгрөг, БАЙр ашиглалттай холбоотой тогтмол зардал 127.2 мянган төгрөгөөр Хангамж, бараа материал 67.7 мянган төгрөгөөр Эд хогшил худалдан авах зардал 216.4 мянган төгрөгөөр Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 109.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Жилийн эцэст 1236.8 мянган төгрөг төвлөрүүлсэн.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах орлогууд орсон

- 13900.0 мянган төгрөг МЗХН УБ төмөр зам 75 хүүхдийн цэцэрлэгийн дулааны өргөтгөл
- 3892.8 мянган төгрөг Онцгой байдлын газар малын нөхөн төлбөр
- 15000.0 мянган төгрөг- Найрамдал энерги ХХК худаг хашаажуулах ажлын зардалд дэмжлэг өгснөөс 3300.0 мянган төгрөг далан худаг хашаажуулахад зарцуулсан, 8850.0 мянган төгрөг олон овоо худгийн хэрэгслийн үнэ төлсөн.
- 458.3-Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд орж ирснээс тээвэр шатахуунд 181.7 мянган төгрөг, Ажлын хөлс-276.6 мянган төгрөг зарцуулсан
- 1399.2 мянган төгрөг Статистикийн хэлтсээс БОСТ зардлын санхүүжилт шилжүүлснээс тээвэр шатахуун-1399.2 мянган төгрөг зарцуулсан.

- 7250.0 мянган төгрөг До.ХАА-н газраас оготно устгалын зардал олгосноос

тээвэр шатахуун -1186.0 мянган төгрөг

цалин -3840.0 мянган төгрөг

томилолт-124.0 мянган төгрөг

Огтоно устгалын багаж-2100.0 мянган төгрөг тус тус зарцуулсан

- 200.0 мянган төгрөг Монгол транс ложистик ховордсон амьтдын хоол хүнсний санхүүжилт орж ирснийг өвс авахад зарцуулсан.

- Хувь хүмүүсээс орсон орлого 580.0 мянган төгрөг байна.

Нийт 50269.7 мянган төгрөгийн санхүүжилтээс 46839.7 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 3430.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэн авлагаар бүртгэсэн

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж, нийт 5 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 22,470.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 7470.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Даланжаргалан сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт албан шаардлага байхгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Нэмэлтийн харилцах дансанд Найрамдал Энержи ГХО ХХК-аас 15,000.0 мянган төгрөгийн хандив төвлөрүүлэн зарцуулсан
- 1.2. Эрсдэл: *Ашиг сонирхлын зөрчил үүсэх*

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 60.2.5 “тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг”-д заасны дагуу ОНХСанд төвлөрүүлэн зарцуулж байх.

- 1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: *Хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,361,364.63</u>	<u>66,023,308.63</u>
33	АВЛАГА	154,956.00	3,430,000.00
335	Бусад авлага	154,956.00	3,430,000.00
3351	Байгууллагаас авах авлага	154,956.00	3,430,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,206,408.63	62,593,308.63
354	Хангамжийн материал	58,831,848.63	60,938,748.63
35410	Бичиг хэргийн материал	1,565,200.00	1,192,700.00
35420	Аж ахуйн материал	49,218,921.30	56,618,321.30
35430	Сэлбэг хэрэгсэл	857,727.33	3,127,727.33
35450	Барилгын засварын материал	7,190,000.00	00.00
35600	Мал амьтад	1,374,560.00	1,654,560.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,415,623,555.61</u>	<u>1,636,108,771.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,415,623,555.61	1,636,108,771.22
392	Биет хөрөнгө	1,344,432,837.07	1,567,054,771.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	370,484,898.57	439,142,867.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-955,200.00	-29,050,263.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,050,500.00	291,750,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-111,890,510.10	-136,595,770.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,452,614.18	132,682,099.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-61,998,208.90	-66,508,869.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	191,111,128.50	207,257,674.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-95,859,125.70	-108,519,029.54
39209	Зам, гүүрийн байгууламж	529,767,980.00	586,727,416.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-113,116,615.27	-157,959,129.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	413,152,188.30	476,788,208.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-61,766,812.51	-68,660,932.15
393	Биет бус хөрөнгө	71,190,718.54	69,054,000.00
39301	Програм хангамж	10,577,264.00	10,577,264.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,840,545.46	-9,977,264.00
39303	Бусад биет бус хөрөнгө	68,454,000.00	68,454,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,475,984,920.24</u>	<u>1,702,132,079.85</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,475,984,920.24</u>	<u>1,702,132,079.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,475,984,920.24	1,702,132,079.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,170,529,816.54	1,170,529,816.54
51101	Өмч: - төрийн	1,170,529,816.54	1,170,529,816.54
512	Хуримтлагдсан үр дүн	177,321,629.49	403,468,789.10
51210	Өмнөх үеийн үр дүн	177,321,629.49	177,321,629.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	226,147,159.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	128,133,474.21	128,133,474.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,475,984,920.24</u>	<u>1,702,132,079.85</u>

1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	662,257,589.70	744,105,984.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,355,564.00	344,318,327.00
120	Нийтлэг татварын бус орлого	280,355,564.00	344,318,327.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	280,355,564.00	344,318,327.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	837,150.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,297,965.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	264,057,599.00	343,481,177.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	381,902,025.70	399,787,657.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	337,097,300.00	349,517,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	337,097,300.00	349,517,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,804,725.70	50,269,757.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,880,034.00	45,679,757.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,924,691.70	4,590,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	440,852,679.13	517,952,776.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,852,679.13	517,952,776.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,126,352.93	515,915,934.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,005,697.00	222,064,441.00
210101	Үндсэн цалин	198,965,697.00	215,344,441.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	6,720,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,948,654.00	27,736,060.00
210201	Тэтгэврийн даатгал	17,092,600.00	19,624,708.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,037,217.00	2,060,344.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,733,726.00	1,850,995.00
210204	Ажилгүйдлийн даатгал	371,368.00	381,827.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,713,743.00	3,818,186.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,527,653.00	17,017,781.00
210301	Гэрэл, цахилгаан	8,266,473.00	9,701,761.00
210302	Түлш, халаалт	3,261,180.00	7,316,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,288,383.00	37,558,814.80
210401	Бичиг хэрэг	5,240,800.00	4,098,050.00
210402	Тээвэр, шатахуун	29,095,523.00	24,767,049.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,556,871.00	3,993,000.80

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	00.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,099,589.00	228,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,295,600.00	4,172,415.00
2105	Нормативт зардал	00.00	45,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	45,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,658,750.00	11,598,605.00
210604	Урсгал засвар	7,658,750.00	11,598,605.00
2107	Томилолт, зочны зардал	10,147,440.00	6,894,994.00
210702	Дотоод албан томилолт	10,147,440.00	6,894,994.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,318,590.00	56,260,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,522,983.00	55,350,184.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	98,320.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	259,506.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,500.00	281,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	140,000.00
210807	Газрын төлбөр	286,787.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,231,185.93	136,739,298.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,503,246.00	2,005,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	139,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,727,939.93	134,595,298.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,726,326.20	2,036,842.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,020,000.00	800,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,020,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,706,326.20	1,236,842.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,706,326.20	1,236,842.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	221,404,910.57	226,153,207.70
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	445,800.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	445,800.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	589,491,779.37	451,848.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,016,754.55	451,848.09
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	588,475,024.82	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-589,491,779.37	-6,048.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-368,086,868.80	226,147,159.61

1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	399,024,456.20	400,637,486.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,122,430.50	849,829.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,122,430.50	849,829.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,122,430.50	849,829.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	849,829.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,122,430.50	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	381,902,025.70	399,787,657.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	337,097,300.00	349,517,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	337,097,300.00	349,517,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,804,725.70	50,269,757.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,880,034.00	45,679,757.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,924,691.70	4,590,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	347,044,956.20	380,784,301.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,044,956.20	380,784,301.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,420,010.00	375,317,458.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,088,377.00	221,508,700.00
210101	Үндсэн цалин	199,048,377.00	214,788,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	6,720,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,748,779.00	27,581,104.00
210201	Тэтгэврийн даатгал	16,342,800.00	19,372,004.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,042,800.00	2,052,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,634,300.00	1,641,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,600.00	410,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,320,279.00	4,104,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,331,653.00	10,477,781.00
210301	Гэрэл, цахилгаан	8,266,473.00	9,701,761.00
210302	Түлш, халаалт	1,065,180.00	776,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,643,628.00	28,070,319.80
210401	Бичиг хэрэг	5,085,550.00	4,409,800.00
210402	Тээвэр, шатахуун	22,003,360.00	18,220,699.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,459,704.00	3,913,300.80
210404	Ном, хэвлэл	00.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,684,964.00	228,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,410,050.00	998,220.00

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	198,400.00	1,494,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	198,400.00	1,494,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,147,900.00	10,409,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	551,300.00	2,691,370.00
210602	Тавилга	460,660.00	00.00
210604	Урсгал засвар	2,135,940.00	7,718,380.00
2107	Томилолт, зочны зардал	12,058,440.00	6,894,994.00
210702	Дотоод албан томилолт	12,058,440.00	6,894,994.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,618,006.00	61,301,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,822,399.00	60,390,654.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	98,320.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	259,506.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,500.00	281,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	140,000.00
210807	Газрын төлбөр	286,787.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,584,827.00	7,579,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,584,827.00	6,199,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,380,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,624,946.20	5,466,842.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,918,620.00	800,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,020,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	898,620.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,706,326.20	4,666,842.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,706,326.20	4,666,842.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51,979,500.00	19,853,185.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	51,979,500.00	19,853,185.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,979,500.00	19,853,185.00
2200	Дотоод эх үүсвэрээр	51,979,500.00	19,853,185.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,979,500.00	19,853,185.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-51,979,500.00	-19,853,185.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,285,816.54	42,356,937.52	545,408,498.29	1,057,051,252.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,285,816.54	42,356,937.52	545,408,498.29	1,057,051,252.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-368,086,868.80	-368,086,868.80
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	177,321,629.49	1,475,984,920.24
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	177,321,629.49	1,475,984,920.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	177,321,629.49	1,475,984,920.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	226,147,159.61	226,147,159.61
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	403,468,789.10	1,702,132,079.85

1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	350,517,900.00	349,130,886.80	1,387,013.20	99.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,517,900.00	349,130,886.80	1,387,013.20	99.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,717,900.00	348,330,886.80	1,387,013.20	99.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,508,700.00	221,508,700.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	214,788,700.00	214,788,700.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,720,000.00	6,720,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,688,600.00	27,581,104.00	107,496.00	99.61
210201	Тэтгэврийн даатгал	19,479,500.00	19,372,004.00	107,496.00	99.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,052,200.00	2,052,200.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,641,900.00	1,641,900.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	410,400.00	410,400.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,104,600.00	4,104,600.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,605,000.00	10,477,781.00	127,219.00	98.80
210301	Гэрэл, цахилгаан	9,400,000.00	9,701,761.00	-301,761.00	103.21
210302	Түлш, халаалт	1,205,000.00	776,020.00	428,980.00	64.40
2104	Хангамж, бараа материалын зардал	25,361,100.00	25,293,344.80	67,755.20	99.73
210401	Бичиг хэрэг	4,410,000.00	4,409,800.00	200.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	15,454,400.00	15,453,724.00	676.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,956,700.00	3,903,300.80	53,399.20	98.65
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	228,300.00	11,700.00	95.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	998,220.00	1,780.00	99.82
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,494,450.00	5,550.00	99.63
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,494,450.00	5,550.00	99.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,205,900.00	22,452,935.00	752,965.00	96.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,350,000.00	11,587,555.00	762,445.00	93.83
210602	Тавилга	3,132,800.00	3,147,000.00	-14,200.00	100.45
210604	Урсгал засвар	7,723,100.00	7,718,380.00	4,720.00	99.94

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	5,737,200.00	5,520,800.00	216,400.00	96.23
210702	Дотоод албан томилолт	5,737,200.00	5,520,800.00	216,400.00	96.23
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,731,400.00	27,621,772.00	109,628.00	99.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,820,000.00	26,711,266.00	108,734.00	99.59
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	260,400.00	259,506.00	894.00	99.66
210804	Тээврийн хэрэгслийн татвар	281,000.00	281,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	140,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6380000.00	6380000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,380,000.00	1,380,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800000.00	800000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГСАНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	350,517,900.00	350,367,729.00	150,171.00	99.96
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	349,517,900.00	349,517,900.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	349,517,900.00	349,517,900.00	0.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	849,829.00	150,171.00	84.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	849,829.00	150,171.00	84.98
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00	-57,281.00	5715.78
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.00
620003	Гэрээт ажилтан	03.00	03.00	0	100

1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,839,757.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,839,757.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,839,757.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,776,975.00
210402	Тээвэр, шатахуун	2,766,975.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,374,194.00
210702	Дотоод албан томилолт	1,374,194.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,389,388.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,389,388.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1199200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,199,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50269757.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,269,757.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	45,679,757.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,590,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	